

## ЭМГ-ын 7 хоногийн мэдээ

### I. Зарим статистик үзүүлэлтүүд

- Нийт төрөлт 58
- Амьд төрөлт 58
- Амьгүй төрөлт 0
- Дутуу төрөлт 1
- Нялхсын эндэгдэл 1
- 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0
- Эхийн ноцтой хүндрэл 0
- Төрөлхийн гажиг 0
- Гэрийн төрөлт 0

Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 15 дахь 7 хоногийн халдварт өвчний эргэн мэдээллийг хүргүүлсэн.

Хачгаар дамжих халдварын эрсдлийг бууруулах, идэвхижлийн үеийг угтуулан хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийгмийн эрүүл мэндийн төвийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Хачигт риккеттиозын сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, ЗӨСТ-ийн халдвар судлаачтай хамтран тандалт судалгаа хийж ажилласан.

2017 оны 13-14-нд Улаанбаатар хотод ЭМЯ, НҮБХАС, НЭМҮТ-ийн хамтран зохион байгуулсан “Нөхөн үржихүйн тусламж, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах нь” сэдэвт 2 өдрийн үндэсний нөлөөллийн уулзалт, сургалтанд хамрагдсан.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмж” хүргүүлсэн.

МСҮТ-ийн 40 оюутанд БЗДХ, сайн дурын зөвлөгөө шинжилгээний ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа явуулсан.

Менингококкт халдвараас сэргийлэх талаар хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр мэдээлэл сургалт сурталчилгаа 1 удаа явуулсан.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, ажилчидын дунд элэгний в, с вирусийн судалгаа хийж дуусах шатандаа явж байна.

2017 оны 04-сарын 17-ний өдөр ХӨСҮТ-ийн үндэсний төвийн Вирус судлалын лабораториаас ирсэн Томуугийн сорьцийн хариуг ЭМГ-ын дарга болон НЭМТөвийн даргад танилцуулж томуугийн нэгжүүдэд эргэн мэдээлэл хийсэн.